

## Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргааны

2017 оны 01-р сарын мэдээ

2017.01.25

### Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт

Хархорин сумын сумын дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран Нарийн хүр багийн нутгаар хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ухуулга сурталчилгаа хийж ажиллаа.



Хамтарсан шалгалтаар тус багийн иргэн Н.Энхбат ТХГНутгаас зохих зөвшөөрөлгүйгээр малын саравчны мод бэлтгэсэн зөрчил илэрсэн тул байгаль экологид учруулсан хохирлыг тогтоолгон / үнэлгээ 845 460 төгрөг / Хархорин сумын Сум дундын цагдаагийн хэлтэст эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар холбогдох материалыг өгөөд байна.

Хамгаалалтын захиргааны даргын баталсан удирдамжийн дагуу Бат-Өлзий сумын ЗДТГазрын байгаль хамгаалагч Д.Пүрэвтогтох, хамгаалалтын захиргааны Бат-Өлзий сумын Хамар хариуцсан байгаль хамгаалагч Ш.Баасансүрэн, Орхоны эх хариуцсан байгаль хамгаалагч, байцаагч Д.Дүгэрдорж, Ханбаян хариуцсан байгаль хамгаалагч Х.Чулуунбат, Хүрхрээ хариуцсан байгаль хамгаалагч М.Мөнхдалай нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус сумын ТХГНутаг болох Могойт, Бага Мойлт, Их Мойлт, Хөнөг, Бугат, Төмөрт, Хамар, Улаан ам, Хурцат, Бөөрөг зэрэг газруудад нутаглаж байгаа 34 өрхийн 124 иргэнд Ойн тухай хуулийн мэдээлэл өгч, хууль бусаар мод бэлтгэхгүй байхыг ухуулан сурталчилж ажиллаа.

Өвөрхангай аймгийн Аудитын газраас Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргааны 2016 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлэн “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, итгэмжлэл үзүүллээ.



### Судалгаа, шинжилгээ

БОЯБУАӨДЗТөслийн нэгжээс мал аж ахуйтай холбоотой төслийн судалгаа ирүүл гэсний дагуу Хашаат, Хархорин, Хужирт суманд тэжээлийн ургамал тариалж дарш бэлтгэх 3 малчны бүлэг, Хотонт, Хархорин суманд сүү, цагаан идээ, арьс нэхий боловсруулах чиглэлээр 3 малчны бүлэгийн судалгааг авч нэгтгэн хүргүүлээ.

БНСУ-ын ижил төстэй салбар байгууллагатай эгч дүүсийн харилцаа тогтоох зорилгоор хамтын ажиллагааны гэрээ, байгууллагын танилцуулгыг монгол, англи хэлээр бэлтгэн боловсруулж БОАЖЯ-ны ТХНУГ-т хүргүүлээд байна.

БОАЖЯ-ны ТХНУГ-т Орхоны хөндийн БЦГ-т аялагч жуулчдын судалгааг сүүлийн 4 жилийн байдлаар гаргаж явууллаа.

Ан амьтанд зориулан биотехникийн арга хэмжээ авах газруудын судалгааг байгаль хамгаалагчдаар гаргуулан цаг хүндэрсэн үед биотехникийн арга хэмжээ авах бэлтгэл ажлыг хангаад байна.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн Ч.Суурьтогтох.